

2018 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Соёл урлагаар үйлчлэх, соён гэгээрүүлэх, хууль сурталчлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлэх чиг үүргийнхээ хүрээнд нэгжид төдийгүй алба хаагч, иргэд олон нийтэд үйлчилгээг хүргэх зорилтыг дэвшүүлж, 2018 оны эхний хагас жилд “Үргэлж тантай хамтдаа” соён гэгээрүүлэх өдөрлөгийг нийслэлийн хэмжээнд Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Баянгол дүүрэг дэх цагдаагийн нэгдүгээр хэлтэс, ЦЕГ-ын Автобааз, Төмөр зам дахь цагдаагийн газар, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг, Хууль зүй, дотоод хэргийн яам, Иргэний агаарын тээвэр дэх цагдаагийн хэлтэс, Мэдээлэл шуурхай удирдлагын төв, Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн хоёрдугаар хэлтэс, Багахангай дүүрэг дэх цагдаагийн хэлтэс, орон нутагт Дорнод, Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газар нийт 13 байгууллагад зохион байгуулав.

Өдөрлөгийн хүрээнд 1595 алба хаагч, 2486 иргэнийг хамруулж, 22 ахмад ажилтан, 33 алба хаагч, тэдний 47 гэр бүлийг алдаршуулж, 27 алба хаагчид төрсөн өдрийн мэндчилгээ хүргэж, 20 аж ахуй, нэгж, иргэдийн хамтын ажиллагааг сурталчлан, талархал илэрхийлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль сурталчлах чиглэлээр 673 алба хаагч, оюутан сурагчдад 9 удаагийн лекц сургалт, “Эерэг хандлага-ээрэг сэтгэлгээ”, “Стрессгүй өдөр”, “Гоо зүйн боловсрол” сэдвээр 1107 алба хаагчийг хамруулан 10 удаагийн лекц, сургалтыг зохион байгуулсан.

7035 хүнд 88 удаагийн бүрэн болон хэсэгчилсэн тоглолтоор үйлчилж, 14 удаагийн нэвтрүүлэг бэлтгэн, 6 телевиз, 9 цахим хуудас, 1 сонин, 1 радио, 11 хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажилласан.

“Таныг алдаршуулья” арга хэмжээний хүрээнд албан үүргээ нэр төртэй биелүүлж, онцгой гавьяа байгуулсан алба хаагчид, алба хаагчийн найдвартай ар тал болж, ажил үүрэг гүйцэтгэх нөхцөл боломжоор хангаж байдаг гэр бүлийн гишүүд, алба хаагчийн авьяаслаг, онц сурлагатан хүүхдийг олон нийтийн дунд алдаршуулан сурталчлах, цагдаагийн ахмад ажилтнуудад хүндэтгэл үзүүлэх, урмын захидал гардуулах, нийгмийн хариуцлагаа ухамсарлан иргэний үүргээ нэр төртэй биелүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд идэвх зүтгэлтэй оролцож цагдаагийн байгууллагатай үр дүнтэй хамтран ажилладаг төрийн болон төрийн бус, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг хамт олон, иргэд, олон нийтийн дунд алдаршуулан сурталчиллаа.

Түүнчлэн аймаг, нийслэлийн их, дээд сургууль, мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургуулийн 1846 оюутан, сурагчдад соёл урлагаар үйлчилж, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулж, 780 хүүхдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан болно.

Цагдаагийн байгууллагаас 2018 онд алба хаагчдын ажлын хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх зорилтыг дэвшүүлсэнтэй холбогдуулан Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн 1 дүгээр хэлтсийн 9, Авто баазын 16, Төмөр зам дахь цагдаагийн газрын 5, Багахангай дүүрэг дэх цагдаагийн хэлтсийн 7 нийт 37 сахилга, ёс зүйн зөрчил гаргасан алба хаагчдад “Итгэл найдварын захидал” захидлыг гардуулсан. Төмөр зам дахь цагдаагийн газрын 5 тасгийн дарга нарт алба хаагчиддаа тавих, хяналтыг сайжруулж, тэднийг сахилга, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэхийг хүссэн захидлыг хүргүүлж, тасгийн дарга нараас ёс зүйн зөрчилгүй, үлгэр жишээч ажиллах тухай амлалтыг захидлын хариугаар хүлээн авсан болно.

2018 онд улсын хэмжээнд “Үргэлж тантай хамтдаа” арга хэмжээг зохион байгуулж дуусгахаар төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд алба, газар, хэлтсүүдээс 2018 оны 26/155 дугаартай албан бичгээр санал авч, нийт 27 алба, газар, хэлтсээс

өдөрлөгийг бие бүрэлдэхүүний дунд зохион байгуулах боломжтой хугацааны талаар саналаа ирүүлэв.

Уран бүтээлийн чиглэлээр: Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудаас ирүүлсэн 34 албан бичиг, хүсэлтийн хүрээнд 31 удаагийн тоглолтын хөтөлбөр боловсруулж, соёл урлагаар үйлчлэв.

Тус чуулгын үлээвэр найрал хөгжмийн бүрэлдэхүүн нийт 92, дуучид 177, бүжигчид 84 удаагийн тоглолтод давхардсан тоогоор нийт 353 удаагийн бүрэн болон хэсэгчилсэн урлагийн тоглолтоор 40500 алба хаагч, иргэд, олон нийтэд соёл, урлагаар үйлчлэхийн зэрэгцээ хөгжмийн 11, дууны 17, бүжгийн 21 бүтээл нийт 49 шинэ уран бүтээлийг туурвиж, чуулгын дуучид өөрсдийн зардлаар 4 клип хийсэн байна.

Бүжигчид мэргэжлийн дасгал сургуулилыг тогтмол гүйцэтгэн бүжгийн бэлтгэл 434 цаг, сонгодог бүжгийн 33 удаагийн 110 цаг, модерн бүжгийн 23 цагийн бэлтгэл хийж ирэв.

Чуулгын бүжигчид мэргэжлийн ур чадвараа сорьж улсын болон олон улсын чанартай тэмцээн уралдаануудад амжилттай оролцож ирлээ. Тухайлбал, “Номадик” компаниас зохион байгуулсан сонгодог, модерн бүжигчдийн улсын уралдааны сонгодог бүжгийн төрөлд бүжигчин, цагдаагийн дэд ахлагч Э.Жаргалмаа, модерн бүжгийн төрөлд бүжигчин Ё.Дамчаабадгар нар “Тэргүүн байр”, бүжигчин Ё.Дамчаабадгар ОХУ-н Кемерова хотод зохиогдсон олон улсын “Ступени” гоцлол бүжигчид, дэглээчдийн VII уралдаанд орчин үеийн бүжгийн төрөлд “Тэргүүн байр”, Монголын урлагийн зөвлөл, АНУ-ын элчин сайдын яам хамтран зохион байгуулсан “Моушн Монголия” орчин үеийн бүжгийн олон улсын наадмын бүжгийн бичлэгийн уралдаанд “Тэргүүн байр”, МУГЖ Д.Алтанхуягийн санаачлагаар Монгол улсын БСШУСЯамны ивээл дор “Монголын балетын хөгжил сан”, Дуурь бүжгийн эрдмийн театр, “Монголын олон улсын тэмцээн зохион байгуулах хороо” хамтран зохион байгуулсан Монголын олон улсын балетын гоцлол бүжигчдийн анхдугаар уралдаанд 11 орны 400 гаруй бүжигчидтэй өрсөлдөж контемпорари бүжгийн төрөлд “Мөнгөн медаль” хүртсэн.

Уран сайхны удирдагч, цагдаагийн хошууч Г.Ариунбаатарын санаачлага, хөрөнгөөр мэргэжлийн дуу бичлэгийн студи шинээр хийж үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус чуулга нь “Үргэлж тантай хамтдаа” шинэ уран бүтээлийн нэгдсэн тоглолт, хөгжимчин, цагдаагийн ахлагч О.Амарсанаа “Drum Атагаа” уран бүтээлийн анхны бие даасан тоглолт, чуулгын дарга, Монголын зохиолчдын эвлэлийн шагналт яруу найрагч, МУСТА, цагдаагийн хурандаа Л.Гаваасүрэн, гэргий СУИС-ын багш, хүндэт профессор, МУУГЗ, хөгжмийн зохиолч Д.Цэцэрлэг, уран бүтээлч охидын хамтаар “Дэлхийн гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан “Ханьсахын жаргал уран бүтээлийн хурим” гэр бүлийн тоглолт зэрэг 3 удаагийн бүрэн хэмжээний тоглолтоо өргөн барилаа.

----- СҮЛД ЧУУЛГА -----